



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 05 дугаар сарын 26
№22 (1367)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

96.	Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай	959
-----	---	-----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

97.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 194	960
-----	-----------------------------	------------	-----

958

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7 дахь хэсэг нэмсүгэй:

“25.7.Иргэн өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх хэсэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Бүрэлдэхүүн хэсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмын хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн дэмжих, эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, салбар дундын дадлагын баазыг бэхжүүлэх арга хэмжээг 2024 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 117 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР

Засгийн газрын 2024 оны 11 дүгээр
сарын 27-ны өдрийн 194 дүгээр
тогтоолын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ
ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ,
ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.10-д заасан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сангийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон энэ журмыг баримтална.

Хоёр.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

2.1.Сангийн хөрөнгө нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29.3-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2.Сангийн хөрөнгийг жилийн төсөвт тусгасны дагуу бүрдүүлнэ.

2.3.Санд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

2.4.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

2.5.Сангийн хөрөнгийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 28.1, 29.4-т заасан зориулалтаар зарцуулна.

2.6.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 28.1, 29.4.1, 29.4.6-д заасан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд гүйцэтгэл, үр дүнг зохих журмын дагуу урьдчилан тооцсон байна.

2.7.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29.4.2, 29.4.3, 29.4.4-т заасан үйл ажиллагааг зохих журмын дагуу тооцсон дундаж норматив зардалд үндэслэн санхүүжүүлнэ.



2.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29.4.5, 29.4.7, 29.4.8-д заасан үйл ажиллагааны зардлыг Сангийн тухайн жилийн төсөвт тусгасны дагуу санхүүжүүлнэ.

2.9.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 28.1-д заасан сургалтын зардалд сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн баяжилтад зориулсан зардал болон хосмог сургалт, гадаад улсад дадлага хийх зэрэг үйл ажиллагааг дэмжин Сангаас санхүүжилт олгож болно.

2.10.Санд энэ журмын 2.3-т заасны дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын дараах арга хэмжээнд хамруулж болно:

2.10.1.мэргэшсэн ажилтан бэлтгэх, давтан болон дагалдан сургах, ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах;

2.10.2.мэргэжлийн ур чадварын түвшнийг тогтоох, үнэлэх;

2.10.3.дадлагажуулагч бэлтгэх, давтан сургах, дэвшилтэт техник, технологи ашиглах асуудлаар хосмог сургалтад хамрагдах.

Гурав.Сангийн удирдлага, үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан удирдаж, хяналт тавьж ажиллана.

3.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.тухайн жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийн дагуу Сангийн хөрөнгийг удирдаж, холбогдох хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу санхүүжилт олгох арга хэмжээг зохион байгуулах;

3.2.2.Сангаас санхүүжилт авсан байгууллагын холбогдох үйл ажиллагааны гүйцэтгэл болон санхүүжилтийн үр дүнд хяналт тавьж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

3.2.3.санхүүжилтийн зарцуулалт, үр дүнтэй танилцах, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

3.2.4.хөрөнгийн бүрдүүлэлт, хандив, тусламж болон санхүүжилтийн талаарх бүртгэлийг хөтөлж, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20.1-д заасан мэдээллийн санд тусгах;

3.2.5.хуульд хаалттай, хязгаарлалттай байхаар зааснаас бусад Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудас болон бусад хэлбэрээр ил тод, нээлттэй олон нийтэд тайлагнах;

3.2.6.Сангийн үйл ажиллагаа, зарцуулалтын талаарх мэдээллийг нэгтгэн зохих журмын дагуу тайлагнах, эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх;

3.2.7.хуульд заасан бусад.

Дөрөв.Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, түүнд тавих хяналт

4.1.Сангаас санхүүжилт авсан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал, жилээр гаргаж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй.

4.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 30.3-т заасны дагуу тайлагнана. Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд энэ журмын 4.1-д заасан байгууллагуудын тайланг хавсаргана.

4.3.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргана. Хянан хэлэлцсэн тайлан, дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

4.4.Зөвлөл тайланг хянан хэлэлцэхтэй холбоотой нэмэлт тайлбар, мэдээлэл, тодруулга шаардсан бол холбогдох мэдээллийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын 15 өдрийн дотор бэлдэж хүргүүлнэ.

4.5.Зөвлөлийн хянан хэлэлцсэн тайлан, дүгнэлтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу боловсролын



асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эцэслэн хянаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.6.Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг танилцуулж болно.

4.7.Сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.3-т заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

Тав.Бусад

5.1.Сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, баталгаа гаргах, энэ журмын 2.4-т зааснаас бусад арга хэмжээг санхүүжүүлэх, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулахыг хориглоно.

5.2.Энэ журмын 4.1-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, 5.1-д заасныг зөрчсөн нь тухайн этгээдэд хариуцлага тооцох, сангаас олгох санхүүжилтийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

5.3.Сангийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, маргааныг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

5.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27.1, 27.2-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.5.Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, баримт, материалыг хуурамчаар бүрдүүлж санхүүжилт авсан бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

----oOo----

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 200003